



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 19 өдөр

Дугаар А/125


Бат-Өлзий сум

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 277 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай” 2022 оны А/394 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, 2022 онд бэлтгэх хадлан, тэжээлийн хуваарийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг төлөвлөгөөний дагуу сайтар зохион байгуулж, хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2022 оны  
08 дугаар сарын 19-ны өдрийн А/125 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт

**ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- Ажлын хэсгийн ахлагч: Н.Орхонтуул ( Сумын Засаг даргын орлогч )  
Нарийн бичгийн дарга: Г.Сугар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)  
Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын байцаагч)  
Н.Түвшин (Бэлчээр газар тариалан хариуцсан мэргэжилтэн )  
М.Мягмаржав (Хүнс жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан )  
Б.Ууганчимэг (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)  
Н.Батжаргал (1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч)  
Ж.Тогоохүү (2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)  
Д.Очирбат (Соёлын төвийн эрхлэгч )  
П.Аюушжав (Мал эмнэлгийн тасгийн дарга)  
Т.Цэнд-Аюуш (Цаг уурч)  
Ж.Нямтогтох (1 дүгээр багийн засаг дарга)  
Д.Бямбасүрэн (2 дугаар багийн засаг дарга)  
С.Төмөр (3 дугаар багийн засаг дарга)  
Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн засаг дарга)  
Л.Балжинням ( 5 дугаар багийн засаг дарга)  
Д.Дэмиддавга (6 дугаар багийн засаг дарга)

Сумын Засаг даргын 2022 оны  
8 дүгээр сарын 12-ны өдрийн 125 дугаар  
захирамжийн хоёрдугаар хавсралт



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН 2022-2023 ОНЫ  
ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 он

Өвт

Д/д	Хийгдэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
<b>Нэг: Удирдлага зохион байгуулалтын талаар</b>			
1	Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах талаар нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авах.	8-11 сард	Засаг дарга
2	ЗДТГ, Сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Соёлын төв болон бусад байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргуулж биелэлтэнд нь хяналт тавих	10 сарын 15-ны дотор	Ажлын хэсэг, байгууллагын удирдлагууд
3	Аймгийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах тухай А/394 дугаар захирамжийн хавсралтын дагуу сумын аюулгүй нөөцөд 80тн өвс, 40тн тэжээл, малчдын түвшинд 2419тн өвс, 806тн гар тэжээл, 1613тн хужир шүүг тус тус бэлтгэх ажлыг зохион байгуулах.	8-9сард	ЗДТГазар, Багийн Засаг дарга нар
4	Хадлан тэжээлийн мэдээг 08 дугаар сарын 30-ны өдрөөс 7 хоног бүрийн 2 дахь өдөр гарган баталгаажуулан сумын ХАА-н тасагт өгөх.	09-10 сард	Багийн Засаг дарга нар
5	Улсын тусгай хамгаалалттай газар болон хилийн зурвас газарт отроор өвөлжих, хаваржих малчин өрх, малын тооны судалгааг урьдчилан гаргаж, холбогдох төрийн байгууллагуудаас зөвшөөрөл авч гэрээний дагуу отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах.	8-11 сард	Багийн Засаг дарга нар
6	Өөр аймаг, сумын нутагт оторлож байгаа малчин өрхийг тухайн орон	Тухай бүр	Багийн Засаг дарга нар

	нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, хобогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах.		
7	Орон нутагт шинээр гаргаж байгаа инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн ажлын чанар, гүйцэтгэлд хяналт хийж, ажлыг хугацаанд нь технологийн дагуу гүйцэтгүүлэн 11 дүгээр сарын 15-ны дотор ашиглалтад оруулан хүлээн авах.	8-11 сард	ЗДТГазар, Гүйцэтгэгч аж ахуйн нэгж
8	Байгаль цаг уурын аюулт үзэгдэлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг малчид, ард иргэдэд цаг алдалгүй байнга хүргэж байх.	Тухай бүр	Цаг-Уурч
9	Сумын аюулгүйн нөөцөд өмнө оны үлдсэн шаардлага хангахгүй өвс тэжээлийг устгалд оруулж цэвэрлэх ажиллыг зохион байгуулах.	8-9 сард	ЗДТГазар, ХАА-н мэргэжилтэнүүд
10	Сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлж өвс, тэжээлийн хүлээн авч хадгалалтын технологийг мөрдөх.	9 сард	Нярав, ХАА-н мэргэжилтэнүүд
11	Отор нүүдлээр явж байгаа малчин өрхийн жирэмсэн эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0-5 насны хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх.	Тухай бүр	Эрүүл мэндийн төв
12	Малчин өрх бүрд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлээ хангах чиглэлээр заавар зөвлөмж өгөх, үүрэн холбооны тархалтыг сайжруулах, өрх бүрд цаг агаарын мэдээ хүргэх, цаг үеийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх.	Тухай бүр	ЗДТГазар, Багийн Засаг дарга нар
13	Ойн цэвэрлэгээ, мод бэлтгэх ажлыг холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд зохион байгуулж, малын хашаа саравч шинээр барих, засварлах, ажлыг зохион байгуулж ажиллана.	Тухай бүр	Ажлын хэсэг, Сум дундын ой анги
14	Зам даваа, гүвээ өвөл хаврын улиралд байнгын бэлэн байлгах, засварлах, хүн хүч, техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах	Тухай бүр	ЗДТГазар Сумын онцгой комисс
<b>Хөдөө аж ахуйн талаар:</b>			
15	Бэлчээрийн ургамлын гарц, байдлыг газар дээр нь үзэж, даац	8-11 сард	ЗДТГ, Багийн Засаг дарга нар

	багтаамж, бэлчээрийн ургац, намаржилтын байдлыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээр, сум дундын отрын бүс нутгийг хамгаалалтад авах, малын хөлөөс чөлөөлөх арга хэмжээ авах.		
16	Ургацын урьдчилсан балансыг гаргаж, ургамлын өвчин хортноос хамгаалах, урьдчилан сэргийлэх, ургац хураалтын үед баримтлах технологийн зөвлөмжөөр хангаж, ургац хураалтын мэдээг бүрэн авч мэдээлэх, төмс, хүнсний ногооны зоорийн тоог нэмэгдүүлэх, хуучин ашиглалтад байгаа зоориудыг засварлах, ариутгалд хамруулж, зоорины бэлэн байдлыг хангах, бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавих.	8-9 сард	ХАА-н мэргэжилтэн
17	Газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд холбогдох мэдээллийг оруулж, цахим системийг нэвтрүүлэх.	8-9 сард	ХАА-н мэргэжилтэн
18	Газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хадгалж, мэдээ мэдээлэл, мэргэжил арга зүйгээр хангаж, ургамал хамгааллын арга хэмжээ, ургац хураалтад дэмжлэг үзүүлэх, урамшуулалд хамруулах.	8-11 сард	ХАА-н мэргэжилтэн
19	Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулагатай байлгах арга хэмжээ авч ажиллах.	8-11 сард	ХАА-н мэргэжилтэн
20	Хээлтүүлэгч малын судалгааг гаргаж, дутагдалтай байгаа хээлтүүлэгчийг тохиромжтой бүс нутгаас нийлүүлэх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулах.	8-11 сард	ХАА-н мэргэжилтэн, Багийн Засаг дарга нар
21	Малын чанар, сүргийн бүтцийн зохист харьцаанд тулгуурлан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бог малын хээлтүүлэгчийг ялган суурилах, чанартай хээлтүүлэгчийг үржилд ашиглах, хээлтүүлэгт орох хээлтэгчийн тоог намаржилтын байдал, малын тарга хүч, ирэх өвөл, хаврын цаг агаарын урьдчилсан төлвийг тооцон тохируулах.	8-11 сард	ХАА-н мэргэжилтэн, Багийн Засаг дарга нар
22	Орон нутгийн болон аймаг дундын улсын тусгай хэрэгцээний отрын	8-12 сард	ХАА-н мэргэжилтэн,

	нөөц нутагт өвөлжүүлж, хаваржуулах мал, малчин өрхийн судалгааг гаргах.		Багийн Засаг дарга нар
<b>Мал эмнэлэгийн талаар:</b>			
23	Мал сүргийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж, шилжилт хөдөлгөөнд хатуу хяналт тавих, сэжигтэй мал, амьтныг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг сум орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх.	8 сараас ирэх оны 5 сар хүртэл	ЗДТГазар, МЭТасаг, Мал эмнэлэг үржлийн нэгж
24	Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, хяналт тавих.	8 сараас ирэх оны 7 сар хүртэл	МЭТасаг, Мал эмнэлэг үржлийн нэгж
25	1.10 Мал сүргийг угаалга, туулгалтад бүрэн хамруулах, сэг зэмийн устгал, халдваргүйтгэлийн ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавих.	8 сараас ирэх оны 7 сар хүртэл	МЭТасаг, Мал эмнэлэг үржлийн нэгж
<b>2. Малчид, мал бүхий иргэдэд</b>			
	2.1 Мал сүрэгтээ тарга хүч авахуулах, малын чанар, сүргийн бүтцийн зохист харьцаанд тулгуурлан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүнсэнд хэрэглэх зэрэг арга хэмжээнүүдийг эртнээс төлөвлөн хэрэгжүүлэх.	Тухай бүр	Багийн Засаг дарга, Малчид
	2.2 Мал өвөлжүүлэх, хаваржуулах бэлтгэлийг сайтар хангах, байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн нөхцөл байдлын үед мал сүргээ хамгаалах, хариулга маллагаанд байлгаж бага насны хүүхдийг малд явуулахгүй байх цаг агаарын мэдээ мэдээллийг тогтмол авч учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх.	Тухай бүр	Багийн Засаг дарга, Малчид
	2.3 Мал сүргээ малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариулга маллагаа хяналтыг сайжруулж, мэргэжлийн байгууллагын заавар зөвлөгөөг сайтар дагаж мөрдөх.	Тухай бүр	Багийн Засаг дарга, Малчид
	2.4 Мэргэжилтний зөвшөөрөлгүй гоц халварт өвчний голомт бүхий бүс нутаг, гадны аймгаас худалдан авч, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх.	Тухай бүр	Багийн Засаг дарга, Малчид

<p>2.5 Мал өвөлжүүлэх хашаа хорооны хөрзөнг ховхолж, малын хэвтэр бууцыг сайн хатаах, хуурай бууцыг хангалттай хэмжээгээр нөөцлөн бэлтгэх, хороо бууц, худаг уст цэгийг засвар тохижилт, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг чанартай хийж гүйцэтгэх, худгийн тагийг сайтар дулаалж хөлдөхөөс хамгаалах.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Багийн Засаг дарга, Малчид</p>
<p>2.6 Малчин өрх бүр хонин толгойд шилжүүлсэн нэг мал тутамд өвс 3 кг, гар тэжээл 1кг, эрдэс тэжээл, хужир шүү 2кг-аар тооцож бэлтгэж нөөцлөх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Багийн Засаг дарга, Малчид</p>
<p>2.7 Өөр аймаг, сумын нутагт оторлож байгаа малчин өрхүүд аль аймаг, сумын нутагт оторлож байгаа мэдээллээ сум орон нутгийн удирдлагууддаа өгч байх.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Багийн Засаг дарга, Малчид</p>
<p>2.8 Малчид өөрсдийн хувийн бэлтгэлээ сайтар хангаж, холбоо барих утас, станцтай байх, дулаан хувцас, хоол хүнс, ус түлш, хүн, малын эмийн сан, хүрз, жоотуу зэрэг багаж хэрэгслийг бэлэн байлгах.</p>	<p>Тухай бүр</p>	<p>Багийн Засаг дарга, Малчид</p>